

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/27

Мандалговь

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1 дэх заалт, Засгийн газрын 1999 оны 96, 2017 оны 24 дүгээр тогтоолууд, аймгийн Засаг даргын 2017 оны А/218 дугаар захирамж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдын сургалт, мэдлэг чадварыг бий болгох хөтөлбөр”-ийг 1 дүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө гарган, түүнд зарцуулах зардлыг жил бүрийн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт болон жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг гаргаж байхыг Хүний нөөцийн мэргэжилтэн, Эдийн засагч нарт даалгасугай.

3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан өөрт холбогдох заалтыг үр дүнгийн гэрээний мэдлэг чадварын зорилтод төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнан дүгнүүлж байхыг нийт албан хаагчдад, энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг УТСХ-ийн дарга, ХШҮ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Г.БАТ-ОРШИХ



Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 03 сарын 27-ны өдрийн
А/27 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



АЙМГИЙН “ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, МЭДЛЭГ ЧАДВАРЫГ БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР”

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үндэслэл:

2017 оны байдлаар аймгийн Эрүүл мэндийн газарт **Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст:** Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн, Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн дэмжих сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, **Эмнэлгийн тусламжийн хэлтэст:** Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, Эмийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Сувилахуй, ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн, Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Гамшиг, яаралтай үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, **Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст:** Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга, Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, мэдээллийн технологи, зайн оношлогоо хариуцсан мэргэжилтэн, Эмийн хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, худалдан авалт хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, Эдийн засагч-1, Нягтлан бодогч-1, статистикч бага эмч-1, архив, даргын туслах-бичиг хэргийн ажилтан-1, жолооч-2, үйлчлэгч-1, нярав-1, сахиул-1, цахилгаанчин-1 нийт 26 албан хаагч ажиллаж байна.

Мэргэжлээр нь авч үзвэл хүүхдийн эмч 2, мэс заслын эмч 1, эх барих эмэгтэйчүүдийн эмч 2, тархвар судлагч эмч 2, эм зүйч 2, дотрын эмч 1, статистикч эмч 1, лаборторын эмч 1, биеийн тамирын эмчилгээний арга зүйч 1, төрийн удирдлагын мэргэжилтэй 1, эдийн засагч 2, нягтлан бодогч 1, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 1, статистикч бага эмч 1, мэдээллийн технологийн мэргэжилтэн 1, жолооч 2, архив, бичиг хэргийн мэргэжилтэн ажилтан 1, цахилгаанчин 1 байна.

Эрүүл мэндийн газарт төрийн захиргааны албан хаагч 14, төрийн үйлчилгээний албан хаагч 12 хүнээс ахлах түшмэлийн тэргүүн зэрэгтэй 1, ахлах түшмэл дөтгөөр зэрэгтэй 1, дэс түшмэлийн дөтгөөр зэрэгтэй 4, дэс түшмэлийн гутгаар зэрэгтэй 1, Дэд зэрэг дэс түшмэл 1 нийт 8 зэрэг дэвтэй төрийн албан хаагч, Тэргүүлэх зэрэгтэй 2 эмч, Эрүүл мэндийн удирдлагын ахлах зэрэгтэй эмч 1, эрүүл мэндийн статистикч ахлах зэрэгтэй 2 мэргэжилтэн, ахлах зэрэгтэй 1 бага эмч, клиникийн профессор 3 эмч, анагаах ухааны магистр 2 эмч ажиллаж байна.

Насны ангилалаар нь авч үзвэл 20-29 насны 4, 30-39 насны 10, 40-49 насны 7, 50-59 насны 4, 60-аас дээш-1 хүн байна.

Сүүлийн 5 жилд эрэгтэйчүүдийн эмчийн олгох 1, тархвар судлалын олгох 2, эмэгтэйчүүдийн эмчийн ЭХО-ийн олгох 2, эрүүл мэндийн удирдлагын олгох 1 нийт 6 эмч, мэргэжилтэнг төрөлжсөн мэргэжилд, архивын мэргэжил дээшлүүлэхэд 1, эм зүйн удирдлагын дээшлүүлэхэд 2 эм зүйчийг, одоо хүүхэд, лабортари чиглэлээр 2 их эмчийг үндсэн мэргэжлээр сургаж байна. Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид 18 хүнээс 61,1% нь төрөлжсөн болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байна.

Жил бүр эмнэлгийн мэргэжилтнүүд улс, бүс болон орон нутгийн хэмжээний мэргэжлийн чиглэлээр болон богино хугацааны сургалтанд бүрэн хамрагдаж багц цагийн биелэлтийг 100%-д хүргэж ажилладаг.

2017 онд Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр Сингапур улсад 7-14 хоногийн мэргэшүүлэх сургалтанд нийгмийн эрүүл мэндийн хэлстийн дарга болон мэргэжилтэн 2 хүнийг хамруулсан.

Төрийн байгууллагын чанар, үр өгөөж нь тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлага, тэдний шинэ бүтээлч санал санаачлагаас ихээхэн хамаарна.

Аймгийн эрүүл мэндийн газрын үйл ажиллагааг үр нөлөө, үр ашигтай явуулах гол нөөц нь албан хаагчид бөгөөд байгууллагын гадаад, дотоод сургалтанд цаг үргэлжид явж мэдлэг чадвараа хөгжүүлж байхыг шаардаж байна.

Энэхүү төрийн албаны зорилт, өсөн нэмэгдэж байгаа шинэ шаардлагыг гагцхүү өндөр мэдлэг чадвар бүхий, мэргэшсэн төрийн албан хаагчдын идэвх, санаачилгатай, бүтээлч үйл ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжүүлж чадна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1 дүгээр заалтыг үндэслэн албан хаагчдынхаа мэдлэг, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын сургалт ба мэдлэг чадвар бий

болгох хөтөлбөрийг боловсруулж, түүнд шаардагдах зардлыг төсөвт тусган жил улирлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллах явдал болж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”, 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” зэрэг нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

1.2 Хамрах хүрээ:

Энэ хөтөлбөрт аймгийн эрүүл мэндийн газрын нийт албан хаагчдад хамрагдана.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ:

2.1.Зорилго:

Эрүүл мэндийн газрын албан хаагчдын хүрээнд мэдлэг чадвар бий болгох, сургаж хөгжүүлэхэд оршино.

2.2 Зорилт:

2.2.1 Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг сургах үйл явцыг ил тод байдлаар хэрэгжүүлэх

2.2.2 Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг өндөр мэдлэг, ур чадвартай болгох, сургах хөгжүүлэх, суралцагч байгууллага болсон байх

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ:

3.1. Хугацаа: 2018-2020

3.2 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.2.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө

3.2.2 Төрийн сан, ЭМГазрын төсөв

3.2.3 Бусад эх үүсвэр, төсөл хөтөлбөр, сан

ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХЭЛБЭР:

4.1. Сургалтын баримтлах зарчим.

4.1.1. Сургалт нь албан хаагчдаас ирүүлсэн эрэлт хэрэгцээ, захиалганд тулгуурлана.

4.1.2. Сургалт зохион байгуулахдаа сургалт зохион байгуулагч төрийн болон төрийн бус байгууллагууд, ЭМЯ, ЭМХТөвтэй нягт хамтран ажиллана.

4.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн чиглүүлж ажиллана.

4.1.4. Сургалтад хамрах бололцооноос хамааруулан суралцагчдыг ажлаас нь чөлөөлөхгүйгээр эсвэл ажиллахын зэрэгцээ суралцах хувилбараар сургалтыг зохион байгуулна.

4.2. Сургалтын хэлбэр.

4.2.1. Мэргэжил олгох, нарийн мэргэжил эзэмшүүлэх

4.2.2. Зайны сургалт

4.2.3. Ажлын байрны сургалт

4.2.4. Мэргэжлийн богино хугацааны сургалт

4.2.5 Хууль эрх зүйн сургалт

4.2.6. Бусад сургалт

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН:

5.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.1.1 Эрүүл мэндийн газрын албан хаагчдад мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах

5.1.2. Албан хаагчдад гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургалтанд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх

5.1.3 Мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор өөрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх энэ хугацаанд тэднийг ажлаас нь чөлөөлөхгүйгээр, эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлсийг олгох зэргээр дэмжлэг үзүүлэх

5.1.4. Шинээр ажилд томилогдсон албан хаагчдыг тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байгууллагын соёл, дотоод журам болон ёс зүйн дүрэм зэрэг шаардлагатай мэдээллээр хангах

5.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн:

5.2.1. Сургалтын хөтөлбөрийг албан хаагчдын хэрэгцээнд тулгуурлан боловсруулдаг болно.

5.2.2. Хувь хүний мэдлэг чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг чадвар, туршлага болгож хөгжүүлэх бөгөөд ингэснээр эрүүл мэндийн газрыг суралцагч байгууллага болгон хөгжүүлнэ.

5.2.3. Өндөр мэдлэг, ур чадвар, туршлага бүхий мэргэжилтнийг бий болгосноор чанартай, хүртээмжтэй бодлого хөтөлбөр боловсруулдаг болно.

5.2.4. Албан хаагчдад итгэх итгэл, эрүүл мэндийн газрын нэр хүнд өснө.

5.2.5. Эрүүл мэндийн газрын дотоод нөөцийг ашиглаж, ажлын байран дээрх сургалтыг хөгжүүлнэ.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ:

4.6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргах

4.6.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар албан хаагчдаас санал, хүсэлт, хөтөлбөрт тодотгол нэмэлт өөрчлөлт оруулах

4.6.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд 1 удаа ЭМГ-ын удирдлагын багт тайлагнах

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
А/27 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**АЙМГИЙН “ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, МЭДЭГ
ЧАДВАРЫГ БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа			Санхүүжилт	Хамтран зохион байгуулагч	Хариуцах эзэн
		2018	2019	2020			
1	Эрүүл мэндийн газрын албан хаагчдаас төрийн сангийн зардлаас үндсэн, мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтын захиалгыг авч, ЭМХТөв-д хүргүүлэх	+	+	+	Байгууллагын төсөв	ЭМХТөв	Хүний нөөцийн мэргэжилтэн
2	Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг үндсэн мэргэжлийн сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	ЭМГ-ын хэлтсүүд	УТСХ-ийн дарга, Хүний нөөцийн мэргэжилтэн
3	Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг төрөлжсөн мэргэжлийн сургалтанд хамруулах	+	+	+	Төрийн сан	ЭМХТөв	Хүний нөөцийн мэргэжилтэн
4	Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах	+	+	+	Төрийн сан	ЭМХТөв	Хүний нөөцийн мэргэжилтэн
5	Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтаны зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах						
6	Эрүүл мэндийн албан хаагчдыг гадаадад туршлага судлуулах болон сургалтанд хамруулах	+	+	+	Төрийн сан	ЭМХТөв	Хүний нөөцийн мэргэжилтэн
7	Эрүүл мэндийн албан хаагчдыг дотоодод туршлага судлуулах	+	+	+	Байгууллага		ЭМГ-ын дарга
8	Угийн бичгийн сургалтанд албан хаагчдыг хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв		ЭМГ-ын дарга, хэлтсийн дарга
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал-эрүүл ахуйн сургалтанд албан хаагчдыг хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв		Хүний нөөцийн мэргэжилтэн
10	Ажлын байр болон зайны сургалтанд албан хаагчдыг хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв		Хүний нөөцийн мэргэжилтэн

11	Албан хаагчдыг жендерийн сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	ЭМХТөв	Хүний нөөцийн мэргэжилтэн
12	Албан хаагчдыг авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Хүний эрхийн үндэсний комисс	Хүний нөөцийн мэргэжилтэн
13	Албан хаагчдыг удирдлагын сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Аймгийн ЗДТГ	Хүний нөөцийн мэргэжилтэн
14	Албан хаагчдыг архивын сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Удирдлагын акадеи, аймгийн ЗДТГ	Хүний нөөцийн мэргэжилтэн
15	Албан хаагчдыг төсвийн сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Аймгийн ЗДТГ	Хүний нөөцийн мэргэжилтэн
16	Албан хаагчдыг эмийн сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Аймгийн Төрийн сан	Хүний нөөцийн мэргэжилтэн
17	Албан хаагчдыг компьютерийн сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Эмийн холбоо	Хүний нөөцийн мэргэжилтэн
18	Албан хаагчдыг ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлагыг сайжруулах сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв		Мэдээллийн технологийн мэргэжилтэн
19	Албан хаагчдыг хууль эрх зүй сургалтанд хамруулах	+	+	+	Байгууллагын төсөв	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны нарийн бичиг
20	Албан хаагчдыг богино хугацааны сургалтуудад тогтмол хамруулж, багц цагаа биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх	+	+	+	Байгууллагын төсөв	Аймгийн хуулийн хэлтэс	Хүний нөөцийн мэргэжилтэн
21	Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг эмч нарын ОПБ хуралд оролцуулах	+	+	+	Байгууллагын төсөв		Хүний нөөцийн мэргэжилтэн
22	Бусад чиглэлээр сургалтанд хмаруулах	+	+	+	Байгууллагын төсөв		Хэлтсийн дарга нар
23	Сургалтанд хамрагдсан хүмүүсийн судалгааг гаргах	+	+	+	Байгууллагын төсөв		Хүний нөөцийн мэргэжилтэн

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХАНГАЛТ, МЭРГЭЖЛИЙН
ЗӨВШӨӨРӨЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Р.МӨНХБАЯСГАЛАН